

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

Н.УЧРАЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2003 ОНЫ 42 ДУГААР ТОГТООЛЫН
ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Геодези, зураг зүйн тухай хуулийн 11.3.1 дэх заалтад “эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объектын нэр газар зүйн нэрэнд хамаарна” гэж, 5.1.3 дахь заалтад “Улсын Их Хурал газар зүйн нэрийг батална” гэж, мөн хуулийн 11.8 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна” гэж, Монгол Улсын 2005 онд нэгдэн орсон ЮНЕСКО-ийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцод “Улсын Их Хурлаар албажуулан баталсан нэрийг сум, дүүргийн Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хамгаална” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Наймдугаар зүйлийн 1-д “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн”, Монгол хэлний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “төрийн албан ёсны хэл” гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг”, 6 дугаар зүйл “Монгол хэлийг хэрэглэх”-ийн 6.1.7 дахь заалтад “Газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг” гэж заасан.

Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1 дэх заалтад “эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект”-ын нэр газар зүйн нэрэнд хамаарна, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Улсын Их Хурал газар зүйн нэрийг батлахаар”, 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт “Засгийн газар газар зүйн нэрийг нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна” гэж тус тус заасан.

1.2. Практик шаардлага:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны “Газар нутгийн нэрийг тодруулан тогтоож, журамлах зарим арга хэмжээний тухай” 280 дугаар тогтоолоор Газар нутгийн нэрийн байнгын комиссийг байгуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг 1980-1985 онд хийж, улмаар Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор нийт 214805 нэр батлагдаж, бүх төрлийн масштабтай байр зүйн болон газрын зураг, атласт тэмдэглэгдэж, улсын хил тогтоох, хаягжуулалт, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тусгай хэрэгцээний газрын байршлыг тогтоох, соёлын өвийг хамгаалах зэрэг олон салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулинд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хилийн цэс, газар зүйн нэрийг хууль бусаар албан ёсны баримт бичиг, газрын зурагт өөрчлөх, газар усны давхар нэр хэрэглэх, албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, өөр бусад хэлний дуудлагаар галиглан бичихийг хориглож, зөрчлийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 6941 газар зүйн нэр, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 8767 газар зүйн нэр батлагдсан.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад газар зүйн нэрийн жагсаалтыг 4 жил тутам тодотгож, Улсын Их Хурлаар батлуулахыг Засгийн газарт үүрэг болгосон. 2019-2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 17 аймгийн 120 сум, нийслэлийн 5 дүүрэг “Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн ажил”-ыг хийж байна.

Үүнээс 2021-2022 онд орон нутгийн төсвөөр Сүхбаатар аймгийн 13 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж 2072 уламжлалт нэрийг нэмж тогтоосон.

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 1980-1984 онд гүйцэтгэсэн газар зүйн нэрийн хээрийн тодруулалтаар 1:100000-ны масштабтай байр зүйн зураг дээр тэмдэглэгдсэн боловч Улсын Их Хурлаар батлагдаагүй 940, байрлал зөрүүтэй 17 нэр, 2021-2022 оны газар зүйн нэрийн хээрийн тодруулалтаар тогтоосон уламжлалт 1132 нэр, мөн Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор үг, үсгийн зөрүүтэй, дүрмийн алдаатай батлагдсан 131 газар зүйн нэр байгааг тогтоож нэрийн жагсаалт гарган, нэр бүрд хувийн хэрэг үүсгэж, мэдээллийн сан бүрдүүлэн, газар зүйн нэрийн зургийг сум бүрээр зохиож тухайн сум, аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл, сумын, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тус тус 2022 онд хэлэлцүүлж Улсын Их Хурлаар батлуулахыг дэмжсэн тогтоол гаргасан.

Сүхбаатар аймагт хийгдсэн Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын үр дүнд шинээр (уламжлалт) бий болсон нэр, өөрчлөлт орох нэр, байрлал зөрүүтэй зэрэг нийт 2220 нэрэнд хяналт шалгалт хийж зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/83 дугаар тушаалаар Барилга, хот байгуулалтын яам, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Усны газар, Шинжлэх ухааны академи, Сүхбаатар аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллан, Улсын Их Хурлын тогтоолоор батлуулахыг дэмжин шийдвэрлэсэн юм.

2020-2021 онд Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан газар зүйн нэрийн судалгааг Баян-Өлгий, Увс, Ховд, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад хийсэн.

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах газар зүйн нэрийг 1:100000-ны масштабтай байр зүйн зураг, бусад баримтаас судалж үзэхэд, 400 газар зүйн нэр монгол хэлнээс өөр хэл (казах, орос, тува г.м) дээр нэрлэгдсэн байж болзошгүйг тогтоосон.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2023 оны захирамжийн дагуу Ажлын хэсэг байгуулагдаж, 2023 оны 03-09 дүгээр сар хүртэл хугацаанд ажиллан 218 монгол бус нэрийн монгол нэрийг суурин судалгаагаар тогтоож, 97 нэрийг газар дээр нь судалж тодруулах шаардлагатай байгааг тогтоосон. 2023 оны 06 дугаар сарын 03-16-ны өдрүүдэд хээрийн судалгааны ажлыг Баян-Өлгий аймгийн 9 сумын

нутагт гүйцэтгэсэн. Судалгааны явцад газар зүйн нэрийг шууд орчуулж нэрлэсэн 100, төсөөтэй байдлаар өөрчлөн нэрлэсэн 142, домог, түүх шинээр зохиож нэрлэсэн 4, хүний нэрээр нэрлэсэн 44, болсон үйл явдлаар хамаатуулан нэрлэсэн 7 нэр тус тус байсныг тогтоосон байна.

Дотоодын болон гадаадын уулчдын авирдаг, замдаа хоноглодог Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт байрлах Монгол Алтайн нурууны мөсөн бүрхүүл бүхий зарим уул, оргил, толгой (“Доод хоног толгой”, “Суварга оргил”, “Бүргэд оргил”, “Наран оргил”, “Өлгий оргил”, “Хар Ямаат уул”)-н нэрийг ууланд авирагчид олон жил ашиглаж ирсэн боловч албан ёсны болж баталгаажуулаагүй байна. Түүнчлэн, иргэд УИХ-ын тогтоолоор батлагдсан, мөн Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гурван улсын хэлэлцээрээр батлагдсан гурван улсын уулзварын цэг болох “Таван Богд уул”-ыг “Найрамдал-2”, “Хүйтэн уул”-ыг Найрамдал-1 гэх мэтээр андуу ташаа нэрлэж байгаа тул үнэн зөв нэрийг таниулан сурталчлах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай юм.

ЗСБНХУ-ын нэрт эрдэмтэн А.Д.Симуковын зохиож, 1938 онд хэвлэгдсэн БНМАУ-ын газрын зурагт тэмдэглэгдсэн, ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар ангийн “Газар зүйн хичээл”-ийн сурах бичигт тэмдэглэгдсэн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн баруун захын цэг “Мааньт уул”-ын нэрийг одоог хүртэл Улсын Их Хурлын тогтоолоор батлуулаагүй байна.

Улсын хилийн дагуу байрлах, 3000 метрээс дээш өндөртэй зарим уулын нэрийг нутгийн иргэдийн одоо хүртэл ашиглаж буй уламжлалт нэрээр нь баталгаажуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, олны хүртээл болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрүүд нь 1980-1985 оны нэрийн тодруулалтаар тогтоогдсон нэр бөгөөд тухайн үеийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн дагуу батлагдсан байдаг. Өөрөөр хэлбэл, 1985 оноос хойш байгуулагдсан 3 аймаг (Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр), 30 сумын нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэр Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолд тухайн үеийн засаг захиргааны нэгжийн нэртэй батлагдсан, ижил төсөөтэй нэрийг байршлаар нь гуйвуулдаг зэрэг шалтгааны улмаас орон нутгийн хилийн цэстэй холбоотой гарсан маргааны тодорхой хэсэг нь газар зүйн нэртэй холбоотой байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Газрын тухай хуулийн дагуу Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах, монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан 319 нэрийн монгол оноосон нэрийг батлах, иргэд одоо хүртэл ашиглаж буй 47 газар зүйн уламжлалт нэрийг нэмэлтээр Улсын Их Хурлаар баталгаажуулж, үнэн зөв газар зүйн нэрийг хойч үедээ өвлүүлэн үлдээх шаардлагатай байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх “Газар зүйн нэрийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн дагуу “Хэлний бодлогын үндэсний зөвлөл”, Шинжлэх ухааны академийн Хэл, зохиолын хүрээлэнгээс санал авч, тогтоолын төсөлд тусгасан.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Тогтоолын төсөл нь 4 заалт, 2 хавсралттай байна. Нэгдүгээр заалт нь эхний хавсралтад заасан 450 газар зүйн нэрийг өөрчлөх тухай, хоёрдугаар заалт нь хоёр

дахь хавсралтад заасан 2101 газар зүйн уламжлалт нэрийг батлах тухай, гуравдугаар заалт нь энэ тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийг газрын зурагт тэмдэглэх, нэрийн мэдээллийн санд бүртгэх, олон нийтэд таниулан сурталчлах тухай, дөрөвдүгээр заалт нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 149 дүгээр тогтоолыг шинэчлэн батлах тухай болон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Баян-Өлгий аймгийн сумдын хилийн цэсийг батлагдсан нэрээр шинэчлэн, Улсын Их Хурлаар батлуулахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгохоор боловсруулна.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Тогтоолын төсөл батлагдсаны дараа монгол хэл дээр батлагдсан газар зүйн нэрийг хойч үедээ өвлүүлэн үлдээх боломж бүрдэх эерэг үр дагавар үзүүлэх бөгөөд нийгэм, эдийн засгийн аливаа сөрөг үр дагавар гарахгүй болно.

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах уулчдын авирдаг, хоноглодог мөсөн уул, толгой, оргилын нэр, солбицол, өндрийг газар дээр нь самбар байрлуулж тэмдэгжүүлэх;

2. Хүчингүй болсон газар зүйн нэрийг газрын зураг дээрээс арилгах, өөрчлөгдсөн, шинэчлэгдэн батлагдсан газар зүйн нэрийг газрын зураг дээр тэмдэглэх, газар зүйн нэрийн мэдээллийн санд бүртгэх;

3. Батлагдсан газар зүйн нэрийг албан ёсны баримт бичигт хэрэглэхийг Засгийн газар, Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд мэдэгдэх, таниулан сурталчлах.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал:

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах тогтоол, шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд:

1. Хүчингүй болсон газар зүйн нэрийг агуулсан аймаг, сумын хилийн цэсийг баталсан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт дахь Баян-Өлгий аймгийн сумдын хилийн цэсийн газар зүйн нэрийг шинэчлэн Улсын Их Хурлаар батлуулах;

2. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 149 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулан Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2003 ОНЫ 42 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын үндсэн хуулийн Наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, Газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5 дахь хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан зарим газар зүйн нэрэнд нэгдүгээр хавсралт ёсоор өөрчлөлт оруулсугай.

2.Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах уламжлалт газар зүйн нэрийг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

3.Энэ тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийг газрын зурагт тэмдэглэх, нэрийн мэдээллийн санд бүртгэх, олон нийтэд таниулан сурталчлахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 149 дүгээр тогтоолыг шинэчлэн батлах, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Баян-Өлгий аймгийн сумдын хилийн цэсийг батлагдсан нэрээр шинэчлэн Улсын Их Хурлаар батлуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН